

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/94/НА-СТА-ТШЗ

|                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |
|-----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот 2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a><br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br>Ахлах аудитор: Н.Гэрэлмаа<br>Утас: 99782918 Цахим хаяг: <a href="mailto:gerelmaan@audit.gov.mn">gerelmaan@audit.gov.mn</a><br>Аудитор: Б.Мөнхболд<br>Утас: 99041008 Цахим хаяг: <a href="mailto:munkhboldbo@audit.gov.mn">munkhboldbo@audit.gov.mn</a> |
|-----------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.24 № 87

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төгрөг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

**Аудитын гол асуудал**

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 171,447.7 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, төвлөрсөн халаалтын системд холбогдсон зэргээс нөлөөлсөн байна.

Тайлант онд төсвийн 43,950.6 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээс 568,231.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан байна.

. 07020404

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 3 хөтөлбөр, 8 зорилт, 85 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийн тайланг хүргүүлснээс сумын Засаг даргаас нийт дүнгээр 92.9 хувиар үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Г.ГҮНЖИДМАА

# Нэг. Аудитын санал дүгнэлт

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

| Үзүүлэлт                                          | 2022.12.31         | 2023.12.31         |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>                  |                    |                    |
| Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 183,545.3          | 233,789.0          |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 1,418,120.3        | 1,566,463.8        |
| <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>1,601,665.6</b> | <b>1,800,252.7</b> |
| Нийт өр төлбөрийн дүн                             | 0.0                | 0.0                |
| Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 1,601,665.6        | 1,800,252.7        |
| <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        | <b>1,601,665.6</b> | <b>1,800,252.7</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>               |                    |                    |
| Үйл ажиллагааны орлогын дүн                       | 909,366.0          | 1,078,416.1        |
| Үйл ажиллагааны зардлын дүн                       | 588,985.3          | 849,329.0          |
| <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>320,380.7</b>   | <b>229,087.1</b>   |
| Үйл ажиллагааны бус үр дүн                        | 0.0                | 30,500.0           |
| <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                | <b>320,380.7</b>   | <b>198,587.1</b>   |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>    |                    |                    |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 1,281,285.0        | 1,601,665.6        |
| Тайлант оны үр дүн                                | 320,380.7          | 198,587.1          |
| <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>1,601,665.6</b> | <b>1,800,252.7</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                   |                    |                    |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 454,056.0          | 758,154.4          |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 451,176.0          | 714,203.7          |
| <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>2,880.0</b>     | <b>43,950.7</b>    |
| <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(2,880.0)</b>   | <b>(43,950.7)</b>  |
| <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 | <b>0.0</b>         | <b>0.0</b>         |
| <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>0.0</b>         | <b>0.0</b>         |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0                | 0.0                |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0                | 0.0                |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ, ОНТ</b>        |                    |                    |
| <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          | <b>407,085.9</b>   | <b>581,489.35</b>  |
| Урсгал зардал                                     | 407,085.9          | 581,489.35         |
| Хөрөнгийн зардал                                  | 0.0                | 0.0                |
| <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             | <b>407,085.9</b>   | <b>605,812.56</b>  |
| <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>             | <b>388,674.6</b>   | <b>586,065.90</b>  |
| Орон нутгийн төсвөөс                              | 388,674.6          | 581,489.35         |
| Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих           | 388,674.6          | 581,489.35         |
| <b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>      | <b>18,411.2</b>    | <b>19,746.66</b>   |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0                | 0.0                |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0                | 0.0                |



## Гурав. Аудитын илрүүлэлт:

### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 23.2 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн тайланд 0.4 сая төгрөгөөр Цалин, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын зүйл ангийг эдийн засгийн ангиллыг зөрүүтэй тайлагнасан.
- Үр дүнгийн тайланд Санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 22.8 сая төгрөгөөр илүү, үр дүнгийн тайланд зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 9.6 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9.6 сая төгрөгийн төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 9.3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар 2 албан шаардлага өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тээвэр шатахууны зардлаас овоо тахилгын арга хэмжээнд 0.3 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан шатахууныг төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

#### 5.2 Албан шаардлага

1. Ажилтны цалин 0.7 сая төгрөгийг нийгмийн даатгал, татварт тайлагнаагүй нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын нөхөн тайлан гаргах албан шаардлага хүргүүлсэн.

2 . Жолоочийн замын хуудсанд тооцоо бодолгүйгээр 8.6 сая төгрөгийн шатахууныг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тээвэр шатахууны зардлыг зарцуулалтыг журмын дагуу тайлагнаж байх албан шаардлага хүргүүлсэн.

### Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл / сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                       | Нийт алдаа |      | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |      | Үүнээс     |      |              |     | Зөвлөмж |     |
|----------------------------------------|------------|------|-----------------------------------|-----|--------------------------|------|------------|------|--------------|-----|---------|-----|
|                                        |            |      |                                   |     |                          |      | Залруулсан |      | Залруулаагүй |     |         |     |
|                                        | Тоо        | Дүн  | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн  | Тоо        | Дүн  | Тоо          | Дүн | Тоо     | Дүн |
| Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар | 1          | 0.4  | -                                 | -   | 1                        | 0.4  | 1          | 0.4  | -            | -   | -       | -   |
|                                        | 1          | 22.8 | -                                 | -   | 1                        | 22.8 | 1          | 22.8 | -            | -   | -       | -   |
| Дүн                                    | 2          | 23.2 | -                                 | -   | 2                        | 23.2 | 2          | 23.2 | -            | -   | -       | -   |

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр                       | Нийт зөрчил |     | Үүнээс        |     |                 |     |         |   |                                      |   |                                                 |   |
|----------------------------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|---|--------------------------------------|---|-------------------------------------------------|---|
|                                        |             |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |   | Хариуцлага тооцуулах албан шаардлага |   | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |   |
|                                        | Тоо         | Дүн |               |     |                 |     |         |   |                                      |   |                                                 |   |
| Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар | 1           | 0.3 | 1             | 0.3 | -               | -   | -       | - | -                                    | - | -                                               | - |
|                                        | 1           | 0.7 | -             | -   | 1               | 0.7 | -       | - | -                                    | - | -                                               | - |
|                                        | 1           | 8.6 | -             | -   | 1               | 8.6 | -       | - | -                                    | - | -                                               | - |
| Дүн                                    | 3           | 9.6 | 1             | 0.3 | 1               | 9.3 | -       | - | -                                    | - | -                                               | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр      | Нийт зөрчил |             | /сая төгрөгөөр/ Үүнээс |          |                 |             |          |          |
|------------------------------------------|-------------|-------------|------------------------|----------|-----------------|-------------|----------|----------|
|                                          |             |             | Төлбөрийн акт          |          | Албан шаардлага |             | Зөвлөмж  |          |
|                                          | Тоо         | Дүн         | Тоо                    | Дүн      | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн      |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил |             |             |                        |          |                 |             |          |          |
| Төгрөг сумын Засаг даргын Тамгын газар   | 1           | 19.0        | -                      | -        | 1               | 19.0        | -        | -        |
| <b>Нийт дүн</b>                          | <b>1</b>    | <b>19.0</b> | <b>-</b>               | <b>-</b> | <b>1</b>        | <b>19.0</b> | <b>-</b> | <b>-</b> |

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |          |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|----------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг    | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |          |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9        | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           | -                  | -               | 1                       |                | -        | -                          |
|   | <b>НИЙТ</b>                 | <b>1</b>                 | <b>1</b>                    | <b>-</b>           | <b>-</b>        | <b>1</b>                |                | <b>-</b> | <b>-</b>                   |